

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(85-89)

**"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН" ДАХЬ  
"ХЭЛЭХ, ӨГҮҮЛЭХ"-ТЭЙ ХОЛБОГДОХ ҮГСИЙН ТУХАЙ**

**Б. Энхсүвд\***

“Монголын нууц товчоо” бол Монголын төдийгүй дэлхийн түүх, хэл соёл, уран зохиол судлалын чухаг хэрэглэгдэхүүн, шавхагдашгүй үнэт дурсгал билээ.

*"МНТ-ны үг, холбоо үг бүрийн тухайн үеийн үгийн сангийн утга орчин цагийн монгол хэл хүртэл хэрхэн улирч хувьсаж, уламжилж хадгалагдаж ирэв гэдгийг судлан шинжлэх нь эрхэм чухаг"*<sup>1</sup> хэмээсний үүднээс энэхүү сурвалжид буй "айлтга-, хэл-, өч-, өгүүл-, донгод-, хэмээ-" гэсэн хэлэх, өгүүлэх, ярихтай холбогдох үгсийг шүүн, утга, хэлбэрийн онцлог шинжийг гаргахыг хичээлээ.

Өнөө цагт амнаас гарч буй үг, өгүүлбэрийг ихэвчлэн ярих, хэлэх гэх болсон бөгөөд бичгийн хэлэнд "өгүүл-" язгуурт үгсийг идэвхтэй хэрэглэсээр байна. Харин дундад үеийн монгол хэлний дурсгалуудад "ярих" гэдэг үгийг огт тэмдэглээгүй бөгөөд "хэлэх, өгүүлэх, донгодох" зэрэг үгсийг ялган хэрэглэж байсныг энэхүү сурвалжаас харж болох юм.

МНТ-ны 152-р зүйлд, *edö'e temüjin kö'ün-tür teyin yabuqsan-iyān umartaju hümegei helige ebürütcü yabumu ker kikün bida ke'eldüba eyin ügüledüksēn üges-i altun-aşuq ong-qan-a ayilatqaju'u*<sup>2</sup> [Эдүгээ Тэмүжин хөвүүнд тийн явснаа умартаж, өмхий элэг өвөртөлж явму. Хэр хийх, бид” хэмээлдэв. Ийн өгүүлэлдсэн үгсийг Алтан Ашух, Ван ханаа (ханд) айлтгажухуй.]<sup>3</sup> хэмээн гарч байна. Тэгвэл энд буй “айлтгажээ” хэмээх нь дээдэст үг хэлэхийн хүндэтгэл үг бөгөөд орчин цагт "айлтгах"-аас гадна “айлдах” буюу дээд тушаалтнаас доод тушаалтанд хандсан хүндэтгэл үгийг албан бичигт өргөнөөр хэрэглэж байна.

\* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

<sup>1</sup>) Чоймаа Ш. (2012), *Монголын нууц товчооны "bida'u" хэмээх үгийн ойр тойронд шинжлэх нь*, МХСС, Монгол судлал, Улаанбаатар, 253-р тал.

<sup>2</sup>) Igor de Rachewiltz (1972), "Index to the Secret History of the Mongols", Bloomington.

<sup>3</sup>) Чоймаа Ш. (2011), "Монголын Нууц Товчоо (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай) шинэ хөрвүүлэг", Улаанбаатар, 99-р тал.

Гэтэл МНТ-ны 282 зүйлийн 233 нь бараг тэр хэвээрээ уламжлан ирсэн<sup>4</sup> Лувсанданзаны "Алтан товч" зохиолд энэ үгийг "*altan esüg ong qayan-ača ayalyulaju altan esüg ögüder-ün*" [Алтан Эсүг (МНТ:Ашуг), Он /Ван, хөр./ хаанаас аялгуулж Алтан Эсүг өгүүлрүүн]<sup>5</sup> хэмээн буулгажээ. "Аялгуулж" хэмээх нь зарлиг болон айлтгалыг сонордуулахдаа, дамжуулсан мэдээ, айлтгалыг дуулан шүлэглэж, аялгуулан хэлдэг байсан гэж Сэцэнцогт тайлбар тольдоо<sup>6</sup> буулгажээ. Тэгвэл МНТ-д "айлтгажээ", ЛАТ-д "аялгуулж" хэмээн хоёр өөрөөр бичсэний тухайд хоёр зүйлийн бяцхан тайлбар байна.

Нэгдүгээрт, тухайн хэсгийг авч үзвэл Ван ханд Алтан Ашух хэлж буйг өгүүлсэн тул "айлтга-" гэдэг нь XIII зууны Хэрэйд аялгуунд хэрэглэж байсан байж магадгүй.

Хоёрдугаарт, монгол бичгээр байсан МНТ-ыг XIV зууны үед хятадаар галиглахдаа алдсаныг ЛАТ-той тулгахад илэрдэг тул "аялгуулж" гэж бичсэн Лувсанданзаных зөв байж болох юм. Яагаад гэвэл, МНТ шиг олон зүйлийн үйл явдлыг өгүүлсэн тийм зохиолд "айлтгах" гэдэг үг ганц удаа тохиолдож байгаа нь эргэлзээ төрүүлж байна.

Мөн өдгөө бид бүхний түгээмэл хэрэглэдэг "хэл- (kele-)" хэмээх үйл язгуур нь XIII-XIV зууны үеийн дурсгалуудад үйл үгээр биш нэр үгээр тохиолддог. Тухайлбал, МНТ-ны §170. *ong-qan dület nadaca cinaru aju'u caqtu nökör buyu anda-tur kele oro'uluva anda qada'ucituqai ...* [5503, 5504] [Ван хан дүлид надаас чинаруу ажгуу. Цагт нөхөр буюу. Андад хэл оруулъя. Анд хатуужтугай!" ...], §200. *basa naiman irgen-i üge-'er ükü'üljü ama-'ar alaju ayu'uluqsan-ıyan adalitqatuqai ke'eju kele ileksen cinu tusa bolju'ui-je* [7529] [Бас Найман иргэнийг үгээр үхүүлж, амаар алж, айгуулснаа (айлгаснаа), адилтгатугай хэмээж хэл илгээсэн чинү тус болжухуй зэ] гэх мэт "оруулах, илгээх, хүргэх" зэрэг үгстэй хамт орж "мэдээ сураг хүргэх, чимээлэх" гэсэн утгыг илтгэх ба орчин цагт ч мөн энэ утгаа хадгалсаар ирсэн билээ.

Харин үйл үг нь "хэллэ- (kelele-)" хэмээх хэлбэрээр тохиолдож буйг МНТ-ны §254. *kö'üd-ün minu aqa joci bui-je ya'u ke'emü ci kelele ke'eba joci-yi dongqotqu-yin urida ca'adai ügüderün joci-yi kelele ke'erün joci-yu'u tüsin ügülemüi ene merkidei cul ulja'ur-a ker mede'ülkün bida ke'eküi-lü'e joci bosu'at ca'adai-yin jaqa-tur tuscu ügüderün* [10310-10311] [Хөвүүдийн минү ах Жочи буй зэ, юу хэмээмүй, чи? хэллэ] хэмээв. Жочийг донгодохын урьд Цагаадай өгүүлрүүн: "Жочийг хэллэ хэмээрүүн, Жочид юу түшин өгүүлмүй. Энэ Мэргидийн чул олзуураа хэр мэдүүлэхүн, бид?" хэмээхүй лүгээ Жочи босоод, Цагаадайн заханд тусч, өгүүлрүүн] зэрэг олон жишээнээс харж болох ба энэ мэт "хэллэ-" язгууртай үг МНТ-д 41 удаа тохиолдож байна.

Энэхүү "kelele- (хэллэ-)" хэмээх үйл үг нь XIV-XVI зууны монгол бичгийн дурсгалуудад цөөнгүй гардаг бөгөөд харин орчин цагийн монгол хэлэнд нэг дор ойрхон орсон хоёр "л" гийгүүлэгчийн нэг нь сугарч, монгол хэлэнд ч, монгол бичигт ч "kele- (хэл-)" болсон байдаг. Тайлбарлавал: "Зах>захал гэдэг шиг хэл гэдэг нэр үгнээ үйл үг бүтээх -ла/-лэ дагавар залгаж үүсгэсэн үг юм.<sup>7</sup> Харин МНТ дахь "хэллэ- (kelele)" язгууртай үгсийн дунд дээрх тайлбараас өөрөөр бүтсэн мэт харагдах дөрвөн үг байна.

<sup>4</sup> Чоймаа Ш. (2011), Лувсанданзаны зохиосон "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой", XVII зууны түүхэн сурвалжийн тулгуур эхүүд-II боть, Улаанбаатар, 1-р тал.

<sup>5</sup> Мөн номын 77-р тал.

<sup>6</sup> Сэцэнцогт. (1998), "Монгол үгсийн язгуурын толь", Хөх хот, 460-р тал.

<sup>7</sup> Цэвэл Я. (2013), "Монгол хэлний товч тайлбар толь", Улаанбаатар, 1041-р тал.

1. **хэлэлдэхүйг**(keleldü=küy-yi §18) 客列<sub>勑</sub>都=恢-宜,

2. **хэлэлдмүй**(keleldü=müi §20) 客列<sub>勑</sub>都=梅, хэмээх үйл үгсийн язгуурыг "kele-" гэж галигласан нь хятадаар галиглагчийн алдаа болов уу. Учир нь эдгээр үгсээс бусад тохиолдолд "kelele" хэмээн галигласанд байгаа юм. Мөн "хэлэлдмүй, хэлэлдэхүйг" хэмээх хоёр үгийн зүйлийн дугаар ойрхон учир алдсан байх магадлалтай.

3. **хэл-лүгээ**(kele=lü'e §85) 客列=魯<sup>8</sup>

МНТ-ны 85 дугаар зүйл, ger-tür inu orobasu sorqan-sira eke-ben de'ü-ner-iyen erin ot ese-'ü kelelü'e bi yekin ireba ci ke'eba [1914] [гэрт инү орвоос, Сорхон Шар: “Эхээн, дүү нараан эрэн од, эсхүү хэллээ, би? Яахан ирэв, чи?” хэмээв]-д байгаа "хэллээ (kelelü'e)" хэмээх үгийг галиглагч "хэл-лүгээ буюу хэлтэй" гэсэн нэр үг гэж ойлгоод "-лүгээ" нөхцөлийн тусад нь "kele=lü'e" хэмээн галиглан бичсэн бололтой.

4. **хэлчилж**(kelečilejü) 客列赤列=周 хэмээх үйл үгийн бүтэц нь "хэл" хэмээх нэр үг дээр тухайн зүйлийг буй болгох явцыг заасан тусах үйл үг бүтээдэг "-чил" дагавар залгаж бүтсэн учраас "kele+čile+jü" хэмээн галиглажээ. Энэ нь "үгчил-(üge+čile), махчил-(miqa+čila)" гэдэгтэй адил бүтэцтэй юм. Үгчлэх гэдэг нь тухайн үгсийг үг үгээр нь буулгахыг хэлдэг бол харин тогтсон дохио үгсийг нэг бүрчлэн хэлэхийг "хэлчилж" гэдэг байсан бололтой.

МНТ дахь “хэл- (kelele-)” хэмээх үгсийг хам сэдвийн хүрээнд авч үзвэл, "аливаа хэргийн учрыг гарган хэлэлцэх"<sup>9</sup> гэсэн утгатай байна. Гэхдээ энэ үг ганц МНТ бус зохиогдсон он цагийн хувьд ойролцоо “Субашид”, “Турфаны цуглуулга”-д ч ийм утгаар тохиолдож байна.

Дундад үеийн монгол хэл болоод орчин цагийн монгол хэлний бичгийн хэлэнд ч хэлэлцэх, ярилцахыг бичигт тэмдэглэдэг үг бол “өгүүл-” үндэстэй үг билээ. Энэхүү үг МНТ-нд 452 удаа тохиолдох бөгөөд үүнээс “өгүүлрүүн(өгүүлэхдээ)” гэсэн хэлбэрээрээ хамгийн олон буюу 306 удаа гарч байна. Жишээ нь, §15. dobun-mergen ya'un gü'ün ci ke'en asaq'asu tere gü'ün ügülerün bi ma'aliq-baya'udai yadaju yabumu tere gög'ö'esün-ü miqan-aca nada ök bi ene kö'ün-be'en cimada öksü kejü'ü [626] [Добун мэргэн “Юун хүмүүн чи?” хэмээн асууваас, тэр хүмүүн өгүүллүүн: “Би Маалиг Баягудай, ядаж явмуй. Тэр гөрөөсний махнаас надад өг. Би энэ хөвүүгээ чамд өгсү” хэмээжүхүй.] Мөн хэмжээний хувьд бусад утга ойролцоо үгсээ бодвол харьцангуй урт, өгүүлэмж их байна.

Мөн түүнчлэн хэлэх, өгүүлэхтэй зайлшгүй холбоотой "өч-" хэмээх үгийн талаар Э.Пүрэвжав, Д.Баасанбат нар "МНТ-ны хэлэнд монгол хэлний хүндэтгэлийн үг хэллэгт хамаарах aldar nere /алдар нэр/ /12486/, "aljiyaqui" /алжаах/ /145-р зүйл/ ... "öčigü" /өчих/ /249-р зүйл/... " зэрэг нэлээд үг хэллэг байгааг цухас дурдья"<sup>10</sup> хэмээн хүндэтгэлийн үг гэж үзжээ. Энэхүү үг нь МНТ-д 28 удаа тохиолдохоос “айлтгах”-ын утгаар 26 удаа, “байцаагдан үнэн үгээ хэлэх”<sup>11</sup> гэсэн утгаар МНТ-ны 197-р зүйлд, edö'e naya'a-daca asaqtala qahan soyurqa'asu tenggeri-yin jayā'ar ecige eke töre'ülüksен mariyan-

<sup>8</sup>) Hitoshi Kuribayashi (2009), Word-Index to the Secret History of the Mongols with Chinese Transcriptions and Glosses (CNEAS Monograph Series No.33), Center for Northeast Asian Studies, Tohoku University, Sendai, 262.

<sup>9</sup>) “qorin nigetü tayilburi toli” (1979), öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 20-р тал.

<sup>10</sup>) Пүрэвжав Э., Баасанбат Д. (2000) "МНТ-ий хэлний хүндэтгэлийн үг", Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал II, УБ., 70-р тал.

<sup>11</sup>) Namjilm-a. (1994), “qorin naimtu tayilburi toli”, öbür mongyol-un keblel, 441-р тал.

nasа asаqu'асu ke'en öci'üljü'üi [7227] [Эдүгээ Наяа-гаас асуутал, Хаан соёрхвоос, тэнгэрийн заяагаар, эцэг эх төрүүлсэн марианаас асууваас” хэмээн өчжүхүй] хэмээн нэг удаа, “асуухуйд хариу өгүүлэх”<sup>12</sup> гэсэн утгаар МНТ-ны 272-р зүйлд, qahan nidün-en ne'eju usun quuju u'uju ya'un bolbi ke'en asaqtaju bö'es öcirün ... [11303] [хаан нүдээ нээж, ус гуйж, ууж, “Юун болов?” хэмээн асуугдаж, бөөс (бөө нар) өчрүүн: ...] хэмээн нэг удаа тохиолдож байна. Үүнээс үзэхэд “өчих” хэмээх үгийг дундад үеийн монгол хэлэнд “айлтгах”-ын утгаар өргөн хэрэглэж байжээ. Харин өнөө цагт энэ утга нь мартагдаж “гэм зэмээ мэдүүлж үнэнээ хэлэх” гэсэн утга нь давамгайлж байна.

МНТ-нд “донгод-” хэмээх үг 16 удаа тохиолдохоос “зэмлэх буруушаах, бурууг заан ухуулах” гэсэн утгаар есөн удаа гарах бөгөөд тухайлбал, §246. cinggis-qahan mönglik-ecige-yi tende dongqodurun kö'üd-ü'en aburi ülü itqan denggecen setkikün bolun teb-tenggeri-yin teri'ün-tür gürba ta [9820] [Чингис хаан Мэнлиг эцгийг тэнд донгодруун: “Хөвүүдийнхээ авир үл ятган, тэнгэцэн сэтгэх болон, Тэв тэнгэрийн тэргүүнд хүрэв, та!], “үг хэлэх, дуугарахаас урьд” гэсэн утгаар долоон удаа гарна. Жишээ нь, §118. ene üge inu uqan yadaju qari'u inu ya'u ba ese ügüleba bi eke-dece asaqsu ke'en ireba bi ke'eba hö'elün-eke-yi dongqodu'a üdü'üi-e börte-üjin ügülerün [3021] [Би энэ үгийг ину ухан ядаж, хариу ину юу бээр эс өгүүлэв, би. Эхээс асуусу хэмээн ирэв, би” хэмээв. Өгээлүн эхийг донгодоогуйа Бөртэ үжин өгүүлрүүн] хэмээсэн хоёр янз утгаар тохиолдоно. Харин орчин цагт “үг хэлэхээс урьд” хэмээх утга нь мартагдаж, ярианы хэлэнд “донгодох, донгосох” гэх бөгөөд энэ нь “зэмлэх, буруушаах, шийтгэх” гэсэн уламжлалт утгаа хадгалсаар байна.

Мөн хэлэх, өгүүлэхтэй утга дүйх “хэмээх” гэх үг нь тухайн үед маш идэвхтэй хэрэглэгдэж байсан бөгөөд МНТ-нд 480 удаа тохиолдож байна. Энэхүү үгийн гарлыг Сэцэнцогт “*ki - kemeten (i - e) kemekü, kemegülkü, kemegdekü, эртний монгол хэлэнд “м”-ээр уртатгаж байсан тул “ke'e” гэсэн дуудлагатай байжээ. Юун хэмээн, Татар хэмээх иргэн, Зүрчинээр ‘sete’ гэнэ*”<sup>13</sup> гэж “хэмээ-” язгуурт үгсийг хий- язгуураас “и-э”-ийн сэлгэцээр үүссэн үүсмэл үг гэж үзсэн бөгөөд профессор М.Базаррагчаа “*кэ мэ-, гэ-” үйл үгийн гарлын утга хадгалах нь*” хэмээх өгүүлэлдээ “*Монгол хэлний бүх өгүүлбэр нь ямагт “гэ-, хэмээ-” үйл үгийн өмнө тохиолдоно. Төгс өгүүлбэр нь ардаа “гэ-, хэмээ-” үйл үггүй боловч холбох үйл үг “гэ-, хэмээ-” нь хоосноор буюу тэг хувилбараар далд хадгалагдаж байдаг. ... Кэмэ- (хэмээх) нь бие хэсэг нь гадагшлан, ирмэг хэсэг нь дотогшлох” гэсэн утгатай кэбэйи- (хэвий), кобуи (ховойх), көбүйи (хөвийх).... зэрэг дүрслэх эхээс эхтэй ...*”<sup>14</sup> гэсэн бол “гэ-“ холбох үгийг дээр дурдсанчлан Сэцэнцогтынхтой адил эгшгийн сэлгэцээр тайлбарлажээ. Гэвч энэхүү гэ-, хэмээ- хэмээх үгийн гарал нь хийхээс (ki-) үү хэл-(kele-) язгуураас гаралтай юу гэдгийг магадалж үзүүштэй мэт санагдана.

Утгын нэг оронд хамаарах төрөл үгсийг хэлний дурсгал, төрөл хэлний баримтад тулгуурлан хэлбэр, утгын хувьслыг нь түүхэн үүднээс цогцоор нь зэргэд авч үзвэл, үг тус бүрийн утга, найруулга, үүргийн хувьд ялгарах онцлогийг нь тодруулах судалгаа илүү найдвартай байх нь дамжиггүй юм.

<sup>12)</sup> “qorin nigetü tayilburi toli” (1979), öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 163-р тал.

<sup>13)</sup> Сэцэнцогт (1998), “Монгол үгсийн язгуурын толь”, Хөх хот, 1026-р тал.

<sup>14)</sup> Базаррагчаа М. (2001), “*Кэ мэ-, гэ-” үйл үгийн гарлын утга хадгалах нь*”, МУИС, ГХСС-ийн ЭШБ, Боть 180(2), Улаанбаатар, 3-21-р тал.

Энэ бүхнээс үзэхэд Монголын Нууц Товчоон дахь хэлэх, өгүүлэхтэй холбогдох үгсийн зарим утга орчин цагт шилжиж өөр утгатай болсон байхаас гадна зарим утга нь бүр мартагдаж хэрэглэгдэхээ больсон байна. Түүнчлэн утгын төдийгүй үгийн бүтцэд ч гэсэн өөрчлөлт гарсныг дээр өгүүлсэн билээ. Мөн цөөн хэрэглэгдэж байсан үг орчин цагт түгээмэл хэрэглэгддэг үг болон хувирсныг айлтгах, өчих үгсийн тайлбараас харж болох юм. Тухайн үеэс нааш өөрчлөгдөн хувирсан утгын болоод үгийн бүтцийн хувирал байгаа ч бичгийн хэлэнд өргөн хэрэглэгдэж, хэн нэгний хэлсэн үг, өгүүлбэрийг бичигт тэмдэглэхэд чухал үүрэгтэй байсаар ирсэн “өгүүл-“ язгууртай үг МНТ-д ч орчин цагийн бичгийн хэлэнд ч тун тогтвортой хадгалагдсаар иржээ.

## RESUME

Speech's semantic brethren '*speak*' and '*say*' to include all forms of verbal expression are commonly used and the root of '*say* (өгүүл-)' is being actively favored in written language. However the word '*speak*' hadn't been occurred in the monuments of Middle Mongolian, the words '*tell*', '*say*', and '*speak respectfully* (айлтгах)' had been used owing to different situations. For example, '*tell*' was generally used for discussing any incident while '*speak respectfully*' for the king or high ranks.

Although, some meanings of these words were forgotten or misunderstood nowadays, they are still kept and used constantly in the vocabulary of the Mongolian language.